



Тагаадын цэргийн алба, амьдрал

“ДАМАНСК-ЖАЛАНАШКОЛИЙН ХИЛИЙН МӨРГӨЛДӨӨН.1969 ОН”

Одоогоос 30 жилийн өмнө Зөвлөлтийн Алс Дорнодод орших Уссури мөрний Даманск арал дээр болон Зөвлөлт Казакстаны “Жаланашколь” заставын хэсэгт болсон хилийн мөргөлдөөний талаар сонсоогүй хүн байдаггүй боловч чухам ямар үйл явдал болсон, байлдааны ажиллагаа хэрхэн явагдсан, яаж төгссөнийг бодит байдлаар нь мэдэх хүн цөөн билээ. Оросын Холбооны Улсын Холбооны Хилийн Албаны төв архивын материал дээр тулгуурлан бичсэн уг баримт материалыг Оросын хэвлэлд анх удаа нийтэлж байгаа бөгөөд уншигч олон та бүхэнд ялангуяа хилийн цэргийн офицер, ахлагч нар хилийн цэргийн дээд сургуулийн сонсогчдод хилийн цэргийн тактик ерөнхий цэргийн тактикийн хичээлээр “Өдөөн хатгалагатай тэмцэх застав, отрядын ажиллагаа”, “Заставын хориглолт”, “Цэрэг улс төрийн байдал хурцадсан үе дэх улсын хилийн хамгаалалт”. “Хүчжүүлсэн манаа”, “Хилийн төлөөлөгчийн ажиллагаа” зэрэг сэдвүүдийг судлах үед лавлах материал, тактик ажиллагааны жишээ болгож байна.

Даманск арал-1969 он

1950 оны сүүлч, 1960 оны эхээр Зөвлөлт Холбоот Улс ба БНХАУ хоёрын хооронд үзэл суртлын хурц тэмцлээс үүссэн онцгой хүндрэл учирсан байлаа. Үзэл суртлын хурц тэмцэл нь найрамдалт хоёр орны харьцааг улам муутган, улмаар улсын хил дээр хоёр талын энгийн иргэд, хилчид, байнгын армийн дайчид оролцсон хилийн зэвсэгт мөргөлдөөнд хүргэсэн билээ.

1960-аад оны 2-р хагаст хамгийн хурц хэлбэрийн мөргөлдөөнүүд Уссури мөрний арлууд дээр гарах болов. Иманск /Уссурийн/ отрядын хариуцсан хэсэгт 119 арал хамаарагдаж байснаас 93 нь Оросын талд, бусад 26 нь Хятадын талын эрэгт харьяалагдаж байлаа. Эдгээр арлын зарим нь маргаантай нутаг дэвсгэр гэгдэж, Хятадын талаас хатуу шаардлага

тавьж байв. Хятадын талын маргаантай нутаг дэвсгэр гэдэгт дараахь арлууд хамаарагдаж байв. Үүнд: Киркинс, Буян, Амбарск, Большой Безимьянный, 3 ба 14-й Шинэ арлууд, ялангуяа Хятадууд Даманск арлын талаар хатуу байр суурьтай байв.

Зөвлөлтийн тал маргаантай гэгдэх нутаг дэвсгэрийн асуудлыг янз бүрийн түвшинд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхээр олон жилийн турш уйгагүй хөөцөлдөв. Үүний үр дүнд 1969 оны 6 сарын 19-ний ЗХУ ба БНХАУ-ын төлөөлөгчдийн уулзалтаар гарын үсэг зурсан протокол ёсоор Даманск аралд Хятадын энгийн иргэдийг гарахыг зөвшөөрсөн юм.

1960 аад оны сүүлчээр энэ арлын талаарх тэмцэл нь тэр үеийн хамгийн том хилийн мөргөлдөөнд хүргэсэн юм. Даманск арлын нийт талбай 830000м арлын хойд хэсэг нь эрэг орчимдоо асар их хэрчигдсэн, хойноосоо ургаш салхи ба Уссури мөрний урсгалын нөлөөгөөр 3 хэсэг болон хуваагдсан бөгөөд гол татрах үед хэд хэдэн арал болдог. Хятадын талын эргээс 50м өргөн усан зурвасаар тусгаарлагддаг байна.

Дээр үед Даманск арал нь Манжуурт хамаарагдаж, орон нутгийн оршин суугчид тэнд загас барих, өвс бэлтгэх зэргээр ашиглаж байжээ. Цаг хугацаа өөрчлөгдсөнөөр Даманск арал нь Зөвлөлтийн хяналтанд орж, түүнийг Зөвлөлтийн хилчид хамгаалах болжээ. 1960 оны 2-р хагаст байрлаж байсан хилийн отрядын удирдлагуудад дээд штабаас улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулахдаа хилийн дэглэмийн гэрээний заалтуудыг хатуу мөрдөж, Зөвлөлтийн хилчид, орон нутгийн иргэдийн буруугаас улсын хил дээр цагийн байдлыг хурцатгах, хилийн будлиан үүсгэх нөхцөлүүдийг гаргуулахгүй байхыг анхааруулж, Хятадын нутаг дэвсгэртэй залгаа болон нарийн шугамаар тусгаарлагдсан Зөвлөлтийн талын аралд хилийн манаа томилохгүй байх, хил зөрчигчдийг баривчлах болон бусад үйлдлийн үед онцгой анхаарал, тэвчээртэй байхыг сануулж, Хятадын иргэдийн зүг зэвсэг болон бусад байдлаар хүч хэрэглэхийг хориглож байв.

Хятадын талын өдүүлсэн хилийн мөргөлдөөнөөс өмнө олон жилийн турш Даманск арлын чиглэлийг хамгаалж байсан Иманск хилийн отрядын Нежне-Михайловка, Кулебякины сопки заставын хилчид хилийн дэглэм зөрчигчдийг удаа дараа уучилж байв.

Ихэнх тохиолдолд тэдэнтэй заставын дарга ахлах дэслэгч И.И.Стрельников, В.Д.Бубенин нар харилцаж байлаа.

Отрядын удирдлага болон И.И.Стрельниковыг удаа дараа айлган сүрдүүлж, занаж зүхэж, амь насанд нь халдахыг оролдож байсан ч Зөвлөлтийн хилчид хууль ёсоор хатуу шаардлага тавьж, Хятадын иргэдийг арлаас хөөн гаргаж байлаа.

Хил зөрчигчид хилчдийн шаардлагыг тэр бүр биелүүлж, Даманск арлыг орхиж байсангүй. Тэд гар хөл, саваа, цохиур, бууны

ХИЛ СУДЛАЛ

мөрлөгч, шатаагч шингэн бүхий лонх гээд гартаа тааралдсан бүгдийг ашиглаж байнга эсэргүүцдэг байжээ.

1967 онд Иманск отрядын хариуцсан хэсэг хөлөг онгоцоор зөрчсөн зөрчил 45 удаа, Зөвлөлтийн хилчид орон нутгийн иргэдийг дайсагнасан доромжилсон явуулга 4 удаа, 1968 онд хөлөг онгоцоор зөрчсөн зөрчил 71 удаа, хилчид орон нутгийн иргэдийг дайсагнан доромжилсон явуулгыг 132 удаа тус тус үйлджээ.

Хятадын тал 1967 он 1968 оны эхээр улсын хилийн цэрэгжүүлсэн хамгаалалтын нягтралыг ихэсгэж, Зөвлөлтийн заставын бие бүрэлдэхүүн, хил орчмын ард иргэдийг Хятад руу дүрвүүлж урвуулах зорилгоор үзэл суртлын ажиллагаагаа улам идэвхижүүлэх болсон төдийгүй хилийн зурваст Зөвлөлтийн эсрэг өдөөн хатгасан жагсаал, цуглааныг зохиож байв.

Тэрчлэн Хятадын тал дангаараа улсын хилийн шугамыг өөрчлөх, хилийн багана, тэмдэгтийг нутгийн гүнд ахиулж байрлуулах зэрэг үйлдлийг хийх болсон. Үүний зэрэгцээ хил орчимд Хятадын ардын чөлөөлөх армийн анги салбаруудыг байрлуулах, тэдний оролцоотойгоор Уссури мөрний бүх голдрилын дагуу улсын хилийн шугамыг дангаараа шилжүүлэн өөрчлөх ажиллагааг сургуулилах болов.

Иманск хилийн отрядын хариуцсан хэсэгт Зөвлөлтийн хилчид, Хятадын иргэдийн хоорондох анхны том сөргөлдөөн 1967 оны 11 сарын сүүлчээр Киркинский болон Нежне-Михайловка хоёр заставын уулзварт Киркинский арлын хэсэгт болсон юм.

Мөн энд 1968 оны 1-р сард Зөвлөлт-Хятадын хил дээрх тэр үеийн хамгийн том мөргөлдөөн болж хоёр талаас тус бүр 300 орчим хүн, авто болон хуягт техник оролцсон билээ.

1968 оны зун өдөөн хатгасан болзошгүй ажиллагаанд идэвхитэй бэлтгэж буй байдал Даманск арлын хэсэг дэх Хятадын Гунсы хянах постын орчимд ажиглагдах болсон байна.

Энд шинэ хориглох байгууламжуудыг яаралтай барьж, хуучныг сэргээх ажиллагаа идэвхитэй явагдаж, хилийн манааны тоог ихээр нэмэгдүүлж байв.

1969 оны 1.2-р сард Даманск арлын хэсэгт Уссури мөрний мөс болон тус арал руу 15-20 хүнтэй Хятадын хилийн эргүүл, бүлгийг газар орныг судлах болон тагнах, өдөөн хатгасан үйл ажиллагаа явуулах зорилгоор байнга явуулах болов. Энэ үед бараг өдөр бүр Нежне-Михайловка заставын хэсэгт Зөвлөлтийн хилчид, Хятадын иргэдийн хооронд олон хүнийг хамарсан үймээн улмаар гардан байлдаан, зодоон болон өрнөх болов.

1969 оны 1 сарын 23-ны өдөр Даманск арлын өмнөд төгсгөл рүү Хятадын Гунсы постоос явж байсан 30-35 хүнтэй Нежне-Михайловка болон Кулебякины сопки заставын бэлтгэл хүч тулгарсан бөгөөд энд

гардан тулааныг Хятадын тал анх эхэлж зэвсэг хэрэглэж энэ өдөр заставын дарга И.И.Стрельниковыг бууны мөрлөгчөөр цохиж алах оролдлого хийсэн байна.

ЗХУ-ын хилийг бүдүүлгээр зөрчиж байгаа талаар тавьсан эсэргүүцлийг Хятадын тал ердөө хүлээн авахгүй байлаа. Үүссэн цагийн байдал, Хятадын талын өдөөн хатгасан үйл ажиллагаанаас үүдэн Иманск хилийн отрядын удирдлага улсын хилийн хамгаалалтыг бэхжүүлэх талаар нэмэгдэл арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

1969 оны 3 сарын нэгнээс 2-нд шилжих хагас бүтэн сайны шөнө Даманск арлын районд нойтон цас бударч манантай байсан учраас хяналт зохиоход хязгаарлагдмал байлаа.

Отрядын хамгийн ойрын хянах постоос арал хүртэл 800 метр боловч хичдэд шөнийн дуран харааны хэрэгсэл хүрэлцээтэй байгаагүй нь газар орныг бүхэлд нь хяналтанд авахад хүндрэлтэй байв.

Гүйцэтгэх ба цэргийн тагнуулын ажиллагааг муу зохион байгуулсан, отрядын хариуцсан хэсэгт хилийн нисэх хүчийг тагнуулын нислэгт байнга ашиглаагүй зэрэг объектив ба субъектив олон нөхцөлүүдээс шалтгаалж 3 сарын эхний өдрүүдэд Хятадын талаас өдөөн хатгалга, хилийн сөргөлдөөнд идэвхитэй бэлтгэж байгааг илрүүлэхэд хүндрэлтэй байлаа.

3 сарын 2-нд Даманск арлын хяналтанд өртдөггүй баруун өмнө төгсгөлд хятадууд нууцаар батальон хүртэлх явган цэргийг (300 орчим хүн)автомат буу, пулемёт, танк эсэргүүцэх гар гранатомёттойгоор байрлуулжээ.

Хятадын цэргийн албан хаагчдын ихэнх нь (200 орчим хүн) арлын баруун хэсэгт тусгайлан бэлтгэсэн өвс, зэгс, модны навч дэвсгэртэй нуувчинд газар орны өнгөлөн далдлах чанарыг сайтар ашиглан мод, бутны араас буудах бололцоотойгоор байрлаж: Уссури мөрний өөрийн талын эрэгт хэд хэдэн миномёт, их бууны батарей, суурьт болон хүнд пулемётуудыг байрлуулсан байлаа.

3 сарын 2-ны үүрийн үнэгэн харанхуйгаар Даманск арлаар Зөвлөлтийн хилийн манаа цанатайгаар үүрэг гүйцэтгэж явахдаа голын далангийн цаана отож нуугдсан Хятадуудыг ажигласангүй.

Хятадын Гунсы хянах постоос 30 орчим хүний бүрэлдэхүүнтэй бүлэг хөдөлгөөн үйлдэж байгааг Нежне-Михайловка заставын Кофьло хянах постоос илрүүлснээр зэвсэгт мөргөлдөөн Алс Дорнодын цагаар 10 цаг 40 минутад эхлэв.

Хятадууд 11 цагийн орчимд хоёр бүлэг болон хуваагдаж арлыг чиглэжээ. 11.10 цагт энэ бүлгийн 18 хүн арлын өмнөд хэсэг рүү хөдөлж, зүүн эргийн дагуу 30 метр орчим яваад Даманск арлыг баруун хойд талаар нь хөндлөн гарч өөрсдийн цэргийн отолтонд байгаа хэсэг рүү очсон байна.

ХИЛ СУДЛАЛ

12 хүн бүхий үлдсэн хэсэг нь Усури мөрний Зөвлөлтийн талын эргээр тэр зүгт өтгөн ой руу хөдөлгөөн үйлдсэн байна.

Хятадын цэргийн албан хаагчид улсын хилийн зүг хөдөлгөөн үйлдэж байгаа мэдээг хүлээн авмагц Нежне-Михайловка заставын дарга ахлах дэслэгч И.И.Стрельников, отрядын тусгай ангийн төлөөлөгч ахлах дэслэгч Н.Буйневичийн хамт хуягт тээвэрлэгч, 2 автомашин, бэлтгэл хүчний 30 орчим хүнтэйгээр Даманск арал руу хөдөлжээ. Тэд үүссэн цагийн байдлыг үнэлж зоригтой хариуцлагатай шийдвэр гаргаж, улсын хилийг зөрчиж буй талаар эсэргүүцэл тавьж, өөрийн заставын болон Кулебякины сопки заставын бэлтгэл хүчтэй нягт харилцан ажиллагаатайгаар хятадуудад улсын хилийг зөрчүүлэхгүй байх, арлыг бүслэх явдлыг таслан зогсоох ээлжит арга хэмжээг авсан байна.

Ахлах дэслэгч Стрельников, Н.Буйневич нар 5 хилчний хамтаар арлын баруун хойд хэсэгт хятадуудыг мөсөөр угтахаар хөдөлжээ.

Ойролцоогоор 11.20 цагт Стрельников бүлгийнхээ хамтаар хятадын цэргийн албан хаагчидтай хэлэлцээр хийхийг оролдсон боловч бүтээгүй бөгөөд энэ өдрийн хэлэлцээр маш богино хугацаанд онцгой зэрлэг нөхцөлд явагдав.

Зөвлөлтийн хилчдийг ойртож очиход занаж зүхсэн хэдэн өгүүлбэрээр эхэлж байсан хэлэлцээрийг автомат, пулемёт, их бууны гэнэтийн галаар зогсоосон бөгөөд тэдгээрийг тулган буудсаны улмаас 7 хилчин бүгдээрээ алагджээ. Мөн ийм аймшигт байдалд орсон Стрельниковын бүлгийн зэрэгцээ, хойд чиглэлд хөдөлсөн тасгийн захирагч бага түрүүч В.Рабовичийн 13 хүнтэй халхлах бүлгийг отолтоос автомат, пулемёт, грантомётийн шөргөн галаар устгасан байна.

И.И.Стрельниковын бүлгийн араас Даманск аралд Нежне-Михайловка заставын тасгийн захирагч бага түрүүч Юрий Васильевич Бабанскийн удирдсан түгшүүрийн бүлэг ч ирэв. Бага түрүүч Бабанский Зөвлөлтийн хилчдийн удирдлагыг өөртөө авч, дайсны ширүүн галын дор тулалдаанд орж эрэлхэг зоригтой, мэдлэгтэй шийдэмгий дарга болохоо харуулсан юм. Ю.Бабанскийн удирдлагаар Зөвлөлтийн хилчид хятадуудын дайралтыг хэд хэдэн удаа няцааж, 10 гаруй хил зөрчигчдийг өөрөө биечлэн устгажээ.

Сум галт хэрэгсэл дуусахад Ю.Бабанский алагдсан, шархадсан хилчдийн сум галт хэрэгслийг цуглуулан байлдааны ажиллагааг үргэжлүүлэж байхад 11.30 цагт ахлах дэслэгч В.Д.Бубенин, Ю.Бабанский нар хүч хавсарсан ажиллагааны явцад хэд хэдэн дайралтыг амжилттай хийж хятадуудыг хуучин байрлалд нь буцаажээ.

Ахлах дэслэгч В.Д.Бубенин хэдийгээр шархдаж битүү бэртэлт авсан ч байлдааны ажиллагаа түр завсарлах хүртэл 13 цаг удирджээ. 13.30 цагт Даманск арлын Иманск хэсэгт отрядын дарга хурандаа Думократ Владимирович Леонов цэргийн хээрийн сургуулиас нисдэг

тэргээр ирж улсын хилийн хориглон хамгаалалт болон алагдсан шархадсан хилчдийг зөөвөрлөх ажиллагааг зохион байгуулав.

Аймшигтай хүнд нөхцөлд Даманск арлаас 3 сарын 2-нд хятадуудыг хөөн зайлуулж, хилчид тэнд 3 сарын 14-ний өглөө хүртэл байрласан байна.

1969 оны 3 сарын 2-ны хилийн мөргөлдөөний явцад хил орчмын Нежне-Михайловка суурины оршин суугчид хилчдэд идэвхитэй туслав.

Хилийн цэрэгт мтуслах хүчний 3 гишүүн ах дүү Авдеевууд сум галт хэрэгсэл хүргэх, шархдагсдыг зөөвөрлөхөд идэвхитэй оролцжээ.

3 сарын 2-ны эмгэнэлт үйл явдлаас үүдэн Иманскийн хилийн отрядыг Ми-4 нисдэг тэрэгний салаа, 13 хуягт тээвэрлэгч бүхий зэргэлдээ отрядын мото-маневрийн бүлэг, бага дарга бэлтгэх сургуулийн бие бүрэлдэхүүнээр хүч нэмэгдүүлэв. Мөн отрядад хоёр танкийн салаа бүхий хоёр МБР, миномётын батарейг шилжүүлэн өгчээ.

3 сарын 2-ноос 14-ний хооронд Даманск арлын хамгаалалтыг өдрийн цагт хяналтаар болон хуягт тээвэрлэгч бүхий хүчжүүлсэн манааг томилж, эрэг орчмоор 2-3 хуягт тээвэрлэгч бүхий дэмжих бүлгийн хүчээр зохион байгуулж байлаа.

Хятадын тал шинэ зэвсэгт өдөөн хатгалга үйлдэхээр бэлтгэн Зөвлөлтийн хил дээр ихээхэн хэмжээний цэрэг, зэвсэг, техникийг бөөгнөрүүлэх болов.

Тэр өдрүүдэд агаарын ба цэргийн тагнуул хилийн зурваст байсан ихээхэн хэмжээний танк, их буу, миномёт, болон цэргийн тээврийн хэрэгслэлийн идэвхитэй хөдөлгөөнийг илрүүлж байлаа. 3 сарын 14 гэхэд Даманск арлын хятадын талд хороо орчим явган цэрэг байрласан байлаа.

Бүлэглэлийн ар талд Уссури мөрнөөс 10-15 км-т 10-12 их буу ба миномётын батарей байрлаж, хилийн постын бие бүрэлдэхүүнийг 80-120 хүнтэй болгон бэхжүүлж, мөн өдөр хятадын олон хүнтэй бүлгүүд өөрсдийн эзэлж байсан хориглох ба давших заагаас хилийн шугамын дөхөц газар луу хөдөлгөөн үйлдэх болов.

Үүсэн бий болсон онцгой цагийн байдлаас үндэслэн отрядын дарга хурандаа Леонов 3 сарын 15-ны шөнө бүх застав, бэлтгэл салбаруудыг байлдааны бүрэн бэлэн байдалд оруулах, үүрээр Нежне-Михайловка ба Кулебякины сопки заставын бие бүрэлдэхүүнийг хээрийн тулгуурт байр эзлүүлэх, маневр бүлгийн зарим хэсэг, тагнуул ба хамгаалалтын арга хэмжээг хатуу мөрдөн Даманск арлыг хятадуудад алдахгүйгээр бүх хүч хэрэгслэлээр арлыг хамгаалан тогтоон барих тушаал өгөв.

Өгсөн тушаалыг биелүүлэхийн тулд шөнийн 3.40 цагт дэд хурандаа Е.И.Яншины удирдсан маневрийн бүлгийн нэг хүчжүүлсэн застав 4 хуягт тээвэрлэгчтэйгээр арал руу хөдөлж, өглөөний 6 гэхэд Даманск арлын баруун өмнөд хэсэгт хориглолтыг зохион байгуулав. 3

ХИЛ СУДЛАЛ

сарын 15-ны өглөөний 9.30 цагт ахлах дэслэгч Л.Маньковский Даманск арлын баруун өмнөд хэсэгт хятадуудын ихээхэн хэмжээний бөөгнөрсөн хүчийг илрүүлэв. Хятадын талын эргээс 10.05 цагийн үед хүчтэй галлаж эхэлсэн ба Иманск отрядын толгойн хянах пастоос хятадууд арлын өмнө хэсэгт хүч хэрэгслэлээ дахин бүлэглэж, Яншины маневрийн бүлгийн жигүүр лүү цохилт хийхээр бэлтгэж байгаа нь ил харагдаж байв.

Зөвлөлтийн талаас цохилт хийхээр байнгын армийн анги, салбаруудыг хил рүү шилжүүлэн байрлуулж байлаа. 11.15 цагт хятадын рот орчим хүчийг Зөвлөлтийн хилчид устгав.

Энэ үед Яншины бүлэг сум, галт хэрэгслэлээ нөхөн авах, жагсаалаас гарсан техник, бие бүрэлдэхүүнийг солихоор аргагүйдсэн тулалдаанаас гарсан байна.

11.40 цагт зэргэлдээ отрядын хүч нэмэгдүүлсэн бэлтгэл бүлэгтэй Е.Яншины бүлэг хамтарч далангийн дөхөц газарт буй хятадуудад хүчтэй цохилт өгсөн юм. Бүлгүүд хүч тэнцвэргүй байсан бөгөөд Яншины бүлэг их буу болон бусад салбаруудын дэмжлэггүй, гол хүчнээс тасархай ганцаараа байлдааны ажиллагааг явуулж байв.

Энэ өдөр дайсны зэвсэгт өдөн хатгалгыг няцаах байлдааны ажиллагааг отрядын дарга хурандаа В.Д.Леонов удирдав. Зөвлөлтийн хилчдийн хувьд хүнд байдал үүссэн үед тэр 4 танктайгаар хятадуудын ар талд гарч, баруун өмнөд талаас нь яншины бүлэгт туслах оролдлого хийв.

Их бууны дэмжлэггүй, шийдвэртэй, зоригтой хийсэн тулалдааны төгсгөлийн шийдвэрлэх хариуцлагатай байлдааны үед толгойн танкийг танк эсэгүүцэх гранатмётоор устгахад Д.В.Леонов сумны тэсрэлтэд үхлийн шарх авчээ.

3 дугаар сарын 15-нд үд дундаас зөвлөлтийн армийн анги, салбарууд байлдааны ажиллагаанд оролцов. (тийрэлтэт ба хээрийн их буу, явган цэрэг, нисэхийн дайралтын онгоц). Арлын хойд хэсгээс хилийн отрядын маневр бүлгийн хүчээр хэд хэдэн дайралт хийв.

Маневр бүлгийг Иманск отрядын улс төрийн хэлтсийн дарга дэд хурандаа Александр Дмитриевич Константинов удирдаж, байлдааны эгзэгтэй мөчид захирагдагсдад үлгэр дууриал үзүүлэн, хилчид, армийн цэргийн албан хаагчдыг дайралтад зоригжуулан, армийн анги, салбаруудын дарга, захирагч нарт байлдааныг удирдахад туслалцаа үзүүлж байлаа.

Алс Дорнодын цэргийн тойргийн командлагчийн тушал ёсоор 17 цагаас 17.10 цаг хүртэл 135 дугаар МБД-ийн захирагч хятадын амьд хүч, зэвсэг техникийн байрлал руу их бууны хороо, миномётын батарея Град дивизионы халхлах гал нээсэн бөгөөд үүний үр дүнд 20.00 цаг гэхэд байлдааны ажиллагаа үндсэндэ зогсож, эргэн тойрон гал, утаанд бүрхэгдэж, шатсан мод, бут, машин техникийн сэг л үлдэв.

Гэнэт чимээгүй тайван болсон хэдий ч хүн бүхэн энэ бол туладааны төгсгөл биш гэдгийг мэдэрч байлаа.

20.59 цагаас хятадууд 10 миунтын турш их буугаар буудаж, цаашид 30-40 минутын зайтайгаар үргэлжлүүлэн галлаж байлаа. 3 дугаар сарын 16-ны шөнө, зөвлөлтийн хилчид арлыг самнаж, алагдагсад, шархагдсaдыг зөөвөрлөсөн бөгөөд энэ шөнө отрядын дарга Д.В.Леоновыг байлдааны талбараас олсон юм.

Даманск арал дээр заставын хилийн манааг үе үе буудах ажиллагаа 3 дугаар сарыг дуусан дуустал үргэлжилж, 1969 оны 4 дүгээр сар гэхэд байдал нилээд тогтворжиж, 5 сарын эхээр Зөвлөлтийн армийн дайчид арлыг орхиж, хамгаалалтыг хилчдэд шилжүүлэв.

Намар хүртэл үе үе харилцан буудалцсаар байлаа. Эцсийн эцэст 1969 оны 9 дүгээр сарын 10-нд ЗХУ болон БНХАУ хоёрын хооронд Даманск арлын талаар гэрээ байгуулж, арлыг БНХАУ-ын талд шилжүүлсэн. Дараа нь Даманск арлыг хэнд харъяалах маргаанаас зайлсхийж, хятадын тал хиймэл хаалт байгуулж, улмаар Хятадын талын эргийг арлаас тусгаарлаж байсан өөрийн усан зурвасыг шороогоор дүүргэснээр арал гэгдэхээ больсон юм.

Иманск хотын ардын депутатуудын хурлын шийдвэрээр И.И. Стрельников, Д.В.Леонов нарыг Иман хотын төв цэцэрлэгт оршуулж, (одоогийн Дальнереченск хот) Хятадын түргэмгийлэгчтэй хийсэн байлдаанд амь үрэгдэгсэдийн дурсгалд зориулан хөшөө босгожээ. 1969 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар Имансзийн отрядын дарга хурандаа Д.В.Леонов, Нежне-Михайловка заставын дарга, ахлах дэслэгч И.И. Стрельников нарыг нэхэн, мөн Кулебякины сопки заставын дарга ахлах дэслэгч В.Д.Бубенин, тасгийн захирагч бага түрүүч Ю.В.Бабанский нарыг ЗХУ-ын баатар цолоор тус тус шагнажээ.

Улсын хил хамгаалах талаар эх орны өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, Хятадын т алаас явуулсан зэвсэгт өдөөн хатгалгыг таслан зогсооход эрэлхэг гавъяа байгуулсан Иманск хилийн отрядын 217 хилчдийг төрийн дээд шагналуудаар шагнасан байна.

ЗХУ-ын Сайд нарын зөвлөлийн 1969 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор Нижне-Михайловка заставыг И.И.Стрельниковын нэрэмжит, Кулебякины сопки заставыг Д.В.Леоновын нэрэмжит болгон мөнхжүүлжээ.

Улсын хил зөрчигчдийн эсрэг явуулсан хүч тэнцвэргүй тулалдаанд 51 дайчин амь үрэгдсэн боловч хилчид эцсийн сум, амьсгалаа дуустал эх орныхоо төлөө тэмцсэн юм.

“Жаланашколь”

Хилийн энэ мөргөлдөөн нь 1969 оны 8 дугаар сарын 13-нд Казакстаны жижигхэн тосгоны ойролцоо богинохон хугацааны дотор болж өнгөрсөн юм. 65 минут үргэлжилсэн байлдааны ажилагааны Хятадын 50 хүний бүрэлдэхүүнтэй туршлагатай өдөөн хатгагчид, тус бүр 60-70 хүний бүрэлдэхүүнтэй хоёр бүлэг тэднийг дэмжиж оролцсон.

Байлдааны ажиллагааны явцад 19 хил зөрчигчийг устгаж, 3 хүнийг олзолж, маш их хэмжээний буудлагын зэвсэг, гэлт хэрэгсэл, хоёр кино камерыг олзлон авсан юм.

Джунгарын өндөрлөгийг хамгаалж байсан Уч-Аралын хилийн отрядын хэсэгт 8 дугаар сарын 13-наас бүр өмнө Хятадын өдөөн хатгагчид цагийн байдлыг хурцатгах шалтаг шалтгааныг идэвхитэйгээр эрэлхийлэх болсон байна.

8 дугаар сарын 12-нд Родников, “Жаланашколь” заставуудын хилийн манаа хилийн эсрэг талд гарч байсан сэжигтэй чимээ, шуугиан, цэргийн албан хаагчдын хөдөлгөөн, хээрийн холбооны шугам байгуулж байгааг илрүүлсэн.

Хилийн тойргийн командлагч дэслэгч генерал м.К.Меркуловийн шийдвэрээр хятадын талд хилийн уулзалт хийх санал тавьсан боловч товлосон өдөр буюу 8 дугаар сарын 12-нд уулзалт болсонгүй.

Жаланашколь заставын хариуцсан хэсгийн газар орны байдал хятадын талдаа хэд хэдэн ноёлох өндөрлөгүүдтэй, Оросын талынх нь эгц хажуутай намхан өндөрлөгүүд зонхилдог онцлогтой бөгөөд эдгээрийн хоорондуур улсын хилийн шугам дайрч өнгөрдөг байна.

Заставын хэсэг нь инженерийн хувьд сайтар төхөөрөмжлөгдсөн ба онцлог чиглэлүүддээ нуувчтай, армийн инженерийн хэрэгслүүдийн тусламжтайгаар болзошгүй чиглэл рүү гарцтай харилцах шуудууг төхөөрөмжилсөн байлаа. Эдгээр инженерийн байгууламжууд нь хилийн мөргөлдөөний үед хилчдэд, хил зөрчигчид рүү нууцхан дөхөн ойртож, ойрхон зайнаас шөргөн гал нээх бололцоог олгосон байна.

Тухайн үед хилийн манааг хятадын талд олзлогдохоос сэргийлж, хүчжүүлсэн манааг томилж, шөнийн цагт болзошгүй чиглэлүүдэд хүчжүүлсэн нууц манаагаар улсын хилийг хамгаалж байжээ.

Хятадын өдөөн хатгагчид 8 дугаар сарын 13-ны үүрийн үнэгэн харанхуйгаар урьдчилан сонгосон тэмдэгтийг ашиглан улсын хилийн шугамаас 600-700 метрт орших, сүүлд нь Каменная гэж нэрлэгдэх болсон өндөрлөгт тулж иржээ.

Анх тэднийг заставын албаны нохойн сургагч шүүгч Михайл Дулепов илрүүлсэн юм. Зөвлөлтийн хилчид чанга яригч ашиглан орос хятад хэлээр Зөвлөлтийн нутгаас гарч явахыг шаардсан боловч биелүүлээгүй. Энэ чиглэлийг хамгаалахын тулд заставыг отрядын маневрийн бүлгийн хуягт тээвэрлэгчээр хүч нэмэгдүүлсэн байлаа.

Энэ өдөр отрядын байлдааны бэлтгэлийн тасгийн дарга ахлах дэслэгч В.Ольшевский, маневрийн бүлгийн салааны захирагч бага дэслэгч В.Пучков нарын удирдсан байлдааны машины бүрэлдэхүүн жижүүрлэлтийн үүргийг гүйцэтгэж байжээ. Хуягт тээвэрлэгчид хил зөрчигч өдөөн хатгагчдын хажуу талаас гарч ирэхэд тэдний хэн нэг нь хуягт машин руу гал нээв.

Пучков хариу галыг хуягт тээвэрлэгчийн пулемётоор нээсэн бөгөөд байлдааны ажиллагаа цаашид үргэлжлэв. Хуягт тээвэрлэгчид явуут гал нээсээр Каменная өндөрлөгийн урдаас нь хойш тойрон, хятадуудыг дэмжих бүлгээс нь тусгаарламагц, хилчид дайралт хийсэн байна.

Нэг бүлгийг маневрийн бүлгийн штабын даргын туслах, ахмад П.Теребников, нөгөө бүлгийг заставын даргын үүрэг гүйцэтгэгч дэслэгч Е.Говор удирдан, өндөрлөг өөд гарсан. Түрүүч Михайл Дулепов дайралтыг хошуучлан, нөхөд нь түүний араас дайралтад орж, өндөрлөгийн оройд гарсан үед түүнийг дайсны сум оносон юм.

Байлдагч Ватилий Рязнаов хүнд шархадсан бөгөөд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, шархыг нь боосны дараа нисдэг тэргээр эмнэлэг хүргэх замд нас баржээ.

Жаланашколь заставын бие бүрэлдэхүүн дэслэгч Е.Горовын удирдлагын дор эрэлхэг зоригтой байлдан өндөрлөгийг эзэлж, хоёр хил зөрчигчийг олзолсон юм.

Дайралтын үед ахмад Теребников шархдахад байлдагч В.Дедунов, М.Малахов нар даргадаа тусламж үзүүлэн, тэд нөхдөө гүйцэж иржээ. Ахмад Теребников шархадсан ч байлдааны ажиллагааг удирдсаар байжээ.

Байлдааны явцад хуягт тээвэрлэгчийн өмнөөс хятадын гранатомётчин босч ирэхэд байлдагч В.Заворничины буудсан сумны нэг гранатомётын гранатад тусч, дэлбэрэхэд уг гранатомётчин алагдсан сонин тохиолдол болжээ. Ахлах байлдагч В.Пишулевиин хуягт тээвэрлэгчийн экипаж үүргээ сайн гүйцэтгэж, хятадын өдөөн хатгагчдын байрлалд суман мөндөр буулган толгойгоо өндийлгөх сэхээ өгөхгүй байлаа.

Хятадын тал ихээхэн хохирол амссан юм. Хуягт тээвэрлэгч нь гэмтэл авч, найман дугуйныхаа зургааг хага буудуулсан боловч хурдаа хасан, хөдөлгүүрээ үргэлжлүүлэн галлаж байлаа. Пишулевиин баруун гарт сум тусаж, шархадсан боловч зүүн гараагаа хуягт тээвэрлэгчээ жолоодож байжээ.

Бага түрүүч Г.Орищенко, А.Мурзин нар хятадуудын ар талд ашигтай байрлал эзлэн, ухрах замыг нь хаажээ.

Ахлах дэслэгч В.Ольшевскийн удирдсан 8 хүнтэй бүлэг Каменная өндөрлөгийг хажуугаас нь ороон тойрч, хятадын өдөөн

ХИЛ СУДЛАЛ

хатгагчдын ар талд гарснаар, хятадуудын байрлалд айж үймсэн байдал үүсэн, тэд эмх замбараагүй ухарч, ил бай болон устгагдсаар байлаа.

Энэ мөргөлдөөнд Зөвлөлтийн 2 хилчин алагдаж, 8 хилчин шархадсан юм. 8 дугаар сарын 13-ны өглөөний 9.30 цагт хилийн тойргийн командлагч Москва руу утасдан, хилийн зэвсэгт мөргөлдөөн болж, хоёр талаас алагдсан шархадсан хүмүүс байгааг илтгэжээ.

Дээд удирдлагаас аль болохоор амьд хэл, зэвсэг техник, алагдсан хил зөрчигдийг олзолж баримтжуулахын чухлыг анхааруулж, тойргийн командлагч дэслэгч генерал Меркулов Уссурийн мөргөлдөөний сургамжийг санаж, үйл явдлыг сайтар баримтжуулах үүрэг өгсөөр байлаа. Алагдсан хятадуудын хүүрийг 40 градусын халуунд хадгалах бололцоогүйгээс 8 дугаар сарын 14-нд оршуулснаар хилийн энэ мөргөлдөөн дуусжээ.

Түүхэнд 1969 оны Даманск арлын хилийн мөргөлдөөн Жаланашколийн хилийн мөргөлдөөн гэж тэмдэглэсэн энэ үйл явдлуудаас хойш 30 жил өнгөрсөн боловч түүхэн сургамж нь бидэнд үнэтэй хэвээр байна.

Орчуулсан. дэд хурандаа Ц.Ганболд